



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 23 өдөр

Дутаар 1168

Мандалговь

"ЦОДГОР ХҮҮ" өсвөрийн шатрын аварга  
шалгаруулах тэмцээн зохион байгуулах тухай

Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд багачуудын дунд шатрын спортыг түгээн дэлгэрүүлэх, авьяас билгийг нээн хөгжүүлэх зорилгоор "ЦОДГОР ХҮҮ" өсвөрийн шатрын аварга шалгаруулах тэмцээнийг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулсугай.

2. Үйл ажиллагаа зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, төсвийн 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. "ЦОДГОР ХҮҮ" өсвөрийн шатрын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад шаардагдах 832000 (Найман зуун гучин хоёр мянга) төгрөгийн зардлыг нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Залуучуудын хөгжлийн төвийн ажлын албаны нарийн бичиг, ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Х.Төмөрбат)-д даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

2020.10.23

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн  
1168 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт



### **“ЦОДГОР ХҮҮ” ӨСВӨРИЙН ШАТРЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

**Тэмцээний зорилго:** Хүүхэд багачуудын дунд шатрын спортыг сурталчилан дэлгэрүүлэх, тэдний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, орон нутагт хүүхэд багачуудыг оюуны спортоор өргөнөөр хичээллэхийг дэмжих, тэдний ур чадвар, авьяас билгийг нээн хөгжүүлэхэд оршино.

**Тэмцээний хугацаа, байршил:** 2020 оны 10 сарын 31-нээс 11 сарын 01-ний өдрүүдэд Дундговь аймгийн шатрын холбооны /Цэнгэлдэх хүрээлэн 2 давхар 201 тоот/ байранд

**Тэмцээний бүртгэл:** 2020 оны 10 сарын 29-ний 09:00 цагт эхэлж, 10 сарын 30-ны 18:00 цагт хаана. Оролцох багууд мэдүүлгээ **М.Билгүүн** гэсэн facebook хаягаар 10 сарын 29-ны өдөр ирүүлсэн байна.

**Тэмцээний техникийн зөвлөгөөн:** 2020 оны 10 сарын 30-ны 18:00 цагт шатрын холбооны танхимд явагдана. Зөвлөгөөнөөр ширээний шүүгч, маргаан таслах комиссын гишүүд тэмцээний журмыг батлана.

**Тэмцээний насны ангилал:**

- ✓ 5 хүртэлх нас эрэгтэй, эмэгтэй
- ✓ 6-7 нас эрэгтэй, эмэгтэй
- ✓ 8-9 нас эрэгтэй, эмэгтэй
- ✓ 10-11 нас эрэгтэй, эмэгтэй

**Тэмцээн зохион байгуулах журам:** Тэмцээнийг Швейцар системээр оролцогчдын тооноос хамаарч 7-9 өрөг тоглуулна. Оролцогчдын тоо 9 ба түүнээс бага бол тойргийн системээр тоглоно. Цагийн хяналт талдаа 45 минут байна. Тэмцээнийг FIDE-н дүрмийн дагуу болон МШХ-ны дүрмийн дагуу явуулна. Хүлээлгийн цаг 10 минут байна.

**Хайна хагалах:** Хэрэв ижил оноотой гарсан тохиолдолд дараах үзүүлэлтийг харгалзана.

- Хоорондын тоглолт
- Медум бухколц
- Цэвэр хожил
- Бергер
- Хараас тоглосон өргийн үзүүлэлт

**Тэмцээний шагнал урамшуулал:**

- 1-р байр өргөмжлөл, алтан медаль, мөнгөн шагнал
- 2-р байр өргөмжлөл, мөнгөн медаль, мөнгөн шагнал
- 3-р байр өргөмжлөл, хүрэл медаль, мөнгөн шагнал

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн  
1168 дугаар тушаалын 2.2 дугаар хавсралт



**“ЦОДГОР ХҮҮ” ӨСВӨРИЙН ШАТРЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Төмөрбат

Залуучуудын хөгжлийн төвийн  
ажлын албаны нарийн бичиг

Гишүүд


Б.Пүрэвжаргал

Залуучуудын хөгжлийн төвийн сургалт  
хариуцсан ажилтан

Д.Саранзаяа

Залуучуудын хөгжлийн төвийн оролцоо,  
хамтын ажиллагаа хариуцсан ажилтан

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн  
148 дугаар тушаалын 23 дугаар хавсралт



**“ЦОДГОР ХҮҮ” ӨСВӨРИЙН ШАТРЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ**

| №                    | Материалын нэр | Нэг бүрийн үнэ | Тоо   | Хэмжих нэгж | Нийт үнэ |
|----------------------|----------------|----------------|-------|-------------|----------|
| 1                    | Өргөмжлөл      | 2000           | 24    | ш           | 48.000   |
| 2                    | Медаль         | 6000           | 24    |             | 144.000  |
| 3                    | I байр         | 30.000         | 8     | төгрөг      | 240.000  |
| 4                    | II байр        | 20.000         | 8     |             | 160.00   |
| 5                    | III байр       | 10.000         | 8     |             | 80.000   |
| Шүүгчдийн урамшуулал |                |                |       |             |          |
| 1                    | Ерөнхий шүүгч  | 40.000         | 1 хүн | 2 өдөр      | 80.000   |
| 2                    | Талбайн шүүгч  | 10.000         | 4 хүн | 2 өдөр      | 80.000   |
| Нийт                 |                | 832,000        |       |             |          |